



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Орон нутгийн 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитын хураангуй



2023 оны 04 дүгээр сар

Гол дүгнэлт

Орон нутгийн 2022 оны нийт орлогыг 1,981.6 сая төгрөгөөр давуулан биелүүлж, нэгдсэн төсвийн нийт тэнцэл 652.4 сая төгрөг байна.

Орон нутгийн 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд санхүүгийн аудит хийлээ. Увс аймгийн 2022 оны нэгдсэн төсвийн орлогыг өмнөх оны гүйцэтгэлийг суурь болгон төлөвлөсөн байна.

Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулийн хүрээнд Сангийн яамнаас төсвийн нийт орлого ба улсын төсвөөс санхүүжүүлэх дүнг 40,408.9 сая төгрөгөөр хянасан байна.

Сангийн сайдын “Орон нутгийн 2022 оны төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэл, удирдамж”, өмнөх оны орлогын гүйцэтгэлийг тус тус үндэслэн орон нутгийн төсвийн орлогыг аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор 9,300.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 49,709.8 сая төгрөгөөр анх баталсан байна.

Улсын төсөвт тодотгол хийгдсэнтэй холбогдуулан Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1 дэх заалтын дагуу 2022 оны төсвийн тодотголыг боловсруулан, хэлэлцүүлж, орон нутгийн төсвийн нийт орлогыг аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор 46,809.4 сая төгрөгөөр тодотгон баталсан байна.

Орон нутгийн 2022 оны төсвийн суурь орлогыг тодотголоор 18,974.0 сая төгрөгөөр баталсан бөгөөд гүйцэтгэлээр 20,955.6 сая төгрөг төвлөрүүлсэн 114.3 хувиар биелүүлсэн байна.

Орон нутгийн 2022 оны нэгдсэн төсвийн зарлагыг 46,809.4 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 42,162.4 сая төгрөгийг зарцуулжээ. Тайлант оны нийт зарлагын гүйцэтгэл нь өмнөх оноос 43,349.6 сая төгрөгөөр буюу 50.7 хувиар буурахад дараах хүчин зүйлс гол нөлөө үзүүлсэн байна. Үүнд:

- Ковид-19 цар тахлын нөхцөл байдалд зориулан гамшгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээнд 867.0 сая төгрөг төсөвлөснөөс тайлант онд цар тахлын нөхцөл байдал харьцангуй хэвийн байдалд шилжсэнээр 438.3 сая төгрөг зарцуулагдаагүй,
- Хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөс 3,205.6 сая төгрөгөөр зээл олгохоор төсөвлөсөн ч зээлийн эргэн төлөлт хангалтгүй байсны улмаас зээл олголт төлөвлөсөн хэмжээнээс 1,364.6 сая төгрөгөөр дутуу хэрэгжсэн,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд Орон нутгийн төсөвт байгууллагууд тодорхой хэмжээнд хэмнэлт гарган ажилласан, ОНХС болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл, арга хэмжээг гүйцэтгэлд үндэслэн санхүүжүүлсэн.



Халамжийн сан

Орон нутгийн төсвөөс Халамжийн санд 209.5 сая төгрөг батлагдсанаас онцгой тохиолдлын мөнгөн тэтгэмж, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 201.7 сая төгрөгийг зарцуулж 7.8 сая төгрөг хэмнэснийг буцаан төвлөрүүлсэн байна.



Эрүүл мэндийн даатгалын сан

Эрүүл мэндийн даатгалын санд 8,845.9 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр 4,874.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж төлөвлөгөө 3,971.0 сая төгрөгөөр тасарсан байна. 2022 оны гүйцэтгэлээр 31,130.8 сая төгрөг зарцуулсан байна.



Нийгмийн даатгалын сан

Нийгмийн даатгалын санд 32,411.8 сая төгрөгийн орлого оруулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 34,011.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, төлөвлөгөөг 1,599.5 сая төгрөгөөр буюу 4.9 хувиар давуулан биелүүлжээ.

Тайлант онд нийгмийн даатгалын сангийн нэр төрөл бүрээр 83,631.2 сая төгрөгийн зардал гаргахаар төлөвлөсөн ба гүйцэтгэлээр 82,082.5 сая төгрөг зарцуулж төлөвлөснөөс

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах талаар аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчаас харьяа төсвийн захирагч нарт төсвийн төслийг боловсруулахдаа төсөв хэмнэхэд анхаарах, хуулийг мөрдөж ажиллах, төсвийн байгууллага, түүний албан тушаалтны зарим үйл ажиллагаа, хангамжийг хязгаарласантай холбогдуулан төсвийн урсгал зардлын саналд хуулиар хориглосон зардал, арга хэмжээг тусгахгүй байх чиглэл хүргүүлжээ.

Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар хэрэгжүүлсэн горим, сорилын үр дүнд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 27.1 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 7.2 сая төгрөгийн төлбөрийн акт, 18.6 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага, 1.3 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.

Аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 11/01 дүгээр тогтоолоор аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг 92.3 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсэгт “Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 16.5.3 дахь заалтад “батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох” гэж заасны дагуу Төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэдэг 111 төсвийн байгууллага нь батлагдсан бүтэц, орон тоогоор, 3 байгууллагын орон тооны Сангийн яамны хянасан суурь тоо гүйцэтгэлээр зөрүүтэй байна. Засгийн газрын тогтоолд нийцүүлэн баталсан орон тооны төлөвлөлтийг Сангийн яаманд хандаж шийдвэрлүүлэхийг зөвлөмж болголоо.

ДҮГНЭЛТ

1. Увс аймгийн нэгдсэн төсвийн 2022 оны орлого, зарлагыг өмнөх оны гүйцэтгэлд суурилан төлөвлөсөн байна.
2. Увс аймгийн 2022 оны орон нутгийн төсвийн нийт орлогыг төлөвлөснөөс 1,981.6 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.
3. Сангийн яамны хянасан суурь орон тооны төлөвлөгөөнөөс гүйцэтгэлээр 3 байгууллагын орон тоо зөрүүтэй байна.
4. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 3,971.0 сая төгрөгөөр буюу 44.9 хувиар тасарсан байна.
5. Орон нутгийн нэгдсэн төсвийн нийт тэнцэл 652.4 сая төгрөг байна.
6. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал 2022 онд Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг 92.3 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна.
7. Төрийн хэмнэлтийн тухай хууль зохих түвшинд хэрэгжиж байгаа ч хvvпийн зарим зvйл заалттай холбоотой зөрчил байна.

ЗӨВЛӨМЖ

Увс аймгийн Засаг дарга Ч.Чимэд, ЗДТГ-ын СТСХ-ийн дарга Б.Эрдэнэсүрэн нарт:

- 1) Засгийн газрын тогтоолд нийцүүлэн баталсан төсөвт байгууллагын орон тооны төлөвлөлтийг Сангийн яаманд хандаж шийдвэрлүүлэх.
- 2) Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой илэрсэн зөрчилд дүгнэлт хийж, хуулийн хэрэгжилтийг сайжруулахад чиглэсэн бодлого, арга зүйгээр хангаж ажиллах.

ҮАГ-Т ХҮРГҮҮЛЭХ САНАЛ

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны орлогын төлөвлөгөө 3,971.0 сая төгрөгөөр буюу 44.9 хувиар тасарсан байна. Орлогын төлөвлөгөө тасрахад Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын өмнөх оны гүйцэтгэл 4,340.3 сая төгрөг байхад Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газраас 2022 оны орлогын төлөвлөлтийг хийхдээ 8,845.9 сая төгрөг байхаар хэт өсгөж төлөвлөсөн нь гол нөлөөг үзүүлсэн байна.

Иймд Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын төлөвлөлтийг бодитой хийж байхыг Үндэсний аудитын газрын нэгдсэн тайланд тусгуулахаар санал хүргүүлж байна.